



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2024.05.01 № 10

Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль,  
дотуур байрыг орчин үеийн ариун  
цэврийн байгууламжтай болгох  
зорилтын хэрэгжилтийн талаар

Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.5-д "төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулсан.

Ажлын хэсэг энэхүү үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл сонсох, танилцах, орон нутагт ажиллах, зөвлөмж өгөх, чиг үүргээ хэрэгжүүлсээр байна. 2024 оны 03-04 сард ажлын хэсэг зарим аймагт ажиллахад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцтай газар дээр нь очиж танилцахад Техник эдийн засгийн үндэслэлгүй шууд гэрээ байгуулсан, ажлын гүйцэтгэл хангалтгүй, барих, ашиглах, хүлээж авах, хяналт тавих үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Барилгын тухай, Хөрөнгө оруулалтын тухай зэрэг хууль тогтоожид нийцээгүй зөрчлүүд илэрсэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.2020 оноос эхлүүлсэн энэхүү төсөл, арга хэмжээний 1, 2 дугаар үе шатны ажил хийгдэж байгаа хэдий ч батлагдсан ажлын даалгаврын дагуу тооцсон төсөвт өртөг, зарцуулалт бодит бус, угсралтын чанар, стандарт хангалтгүй, техникийн хяналт хийгдээгүй, гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл дутуу, ажлаа үргэлжлүүлэх боломжгүй, хүлээлгэж өгөөгүй зэрэг зөрчлүүд байгааг яаралтай арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

20240501010



2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажилд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас олгосон нийт төсвийн зарцуулалт, үр ашгийн талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийн Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.БАЯРСАЙХАН